



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



2021 оны 4 дүгээр сар

INVEST IN MONGOLIA

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАВ
ДУГААР 03

АГУУЛГА

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТОЙМ

ЗАСГИЙН ГАЗРЫН
БОДЛОГО

ВЕБИНАР БОЛОН
АРГА ХЭМЖЭЭ

МОНГОЛ УЛСЫН ГАДААД
ХУДАЛДААНЫ ОРЧИН

ОНЦЛОХ САЛБАР
ЗАГАСНЫ АЖ АХУЙ

АМЖИЛТЫН ТҮҮХ PwC
КОМПАНИ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ЭРЭЛХИЙЛЖ БУЙ МОНГОЛЫН
ГАРААНЫ БИЗНЕС

МОНГОЛ ХООЛНЫ СОЁЛ ARTGER

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧААС
ГАРГАСАН ГОМДЛЫГ ЦАХИМ
ХЭЛБЭРЭЭР БҮРТГЭХ,
ШИЙДВЭРЛЭЛТЭД ХЯНАЛТ
ТАВИХ СИСТЕМ- SIRM

ЭРХЭМ УНШИГЧ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЭ

Монгол Улсад бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч Та бүхний энэ өдрийн амар амгаланг эрье. Мөн Танд зориулж эрхлэн гаргадаг "Invest in Mongolia" эмхэтгэлийн 4 дүгээр сарын дугаарыг хүргэж байгаадаа таатай байна.

Дэлхий дахиныг хамарсан цар тахалтай тэмцэхийн тулд улс орнууд вакцинжуулалтыг эрчимтэй хийж байна. Монгол Улсын хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эхэлсэн КОВИД-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын аян төлөвлөгөөний дагуу хэрэгжиж өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод гурван хүн тутмын нэг нь коронавирусийн эсрэг вакцины эхний тунгаа хийлгэсэн.

Мөн Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулган 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эхэлсэн ба нийт 50 хуулийн төслийг хэлэлцэхээр дараалал тогтоосон.

Үүнд Үндэсний Хөгжлийн газар нь "Монгол улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" улсын их хурлын тогтоолын төсөл, "Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилгын үндэсний зорилгот түвшин, шалгуур үзүүлэлт батлах тухай" улсын их хурлын тогтоолын төсөл, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төсөлд анхаарал тавин ажиллаж байна.

Бид 2021 онд Хөрөнгө оруулалтын шинэчлэл хийж, илүү таатай хууль эрх зүйн орчин, нээлттэй зах зээлийг бий болгохоор зорилт тавин ажиллаж байгааг дуулгахад таатай байна.

Энэхүү товхимолтой холбоотой санал хүсэлтийг манай газрын info@nda.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Үндэсний хөгжлийн газрын хөрөнгө оруулалтын бодлого, олон талт харилцаа хариуцсан дэд дарга


Б.БУЛГАНЧИМЭГ

МОНГОЛ УЛСЫН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Монгол Улсад 2010-2020 оны хооронд 5,058 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж 26 орчим тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 112 орноос хийсэн байна.

Монгол улсад 2010-2020 онд хийгдсэн гадаадын хөрөнгө оруулалтыг улсаар ангилж үзэхэд Канад улс 7,72 тэрбум ам.доллароор эхний байранд ордог ба БНХАУ, Нидерланд,


МОНГОЛ УЛСАД ОРСОН ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ(ОНООР)



Люксембург, Сингапур зэрэг улсууд топ 5-н хөрөнгө оруулагчаар тодрод байна.

Мөн хөрөнгө оруулалтын дийлэнх нь буюу 70 орчим хувь нь геологи, уул уурхайн салбарт хийгдсэн нь нэг талаас Монгол Улсын хөрөнгө оруулалтын чиг хандлага уул уурхайн салбар руу чиглэсэн байгааг, нөгөө талаас энэ салбар нь бусад эдийн засгийн салбарыг бодвол өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байгаа болно.

ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОО (ОНООР)



АЖЛЫН БАЙР

Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 2,148 ААН байгууллага байна. Эдгээрт нийт 54,971 ажилтан ажиллаж байгаагаас 51,090 нь Монгол, 3,881 нь гадаад ажилчид ажиллаж байгаа бөгөөд нийт цалингийн сан 1,015,268,044,306 /төг/, ААНБ-ын төлсөн НДШ-ийн дүн 208,801,554,545 /төг/ байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн 2020 оны татвар төлөлт 1,228,822,314,724 /төг/ байгаа нь 2019 оноос 7.36% ийн бууралттай байна.

Мөн гадаадын хөрөнгө оруулалттай ААН-үүдийн татвар төлөлт нь 2020 онд нэг бүр 150 хүүхдийн багтаамжтай 614 цэцэрлэг барьж байгуулах өртөгтэй байхаар байна

/Цэцэрлэг нэг бүрийн үнийг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 28-дугаар хороонд 2018 онд баригдсан 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөл дээр үндэслэн Барилга, байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм БД 81-106-16-аар гарган тооцсон болно/

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй **ААН-ийн тоо: 2,148**

ААН-үүдийн нийт **ажилчдын тоо: 54,971**

93%



7%



2020 онд нийт ажилчдад олгосон цалингийн хэмжээ **1,015,268,044,306** буюу дундаж сарын цалин **1,539,096**. Монгол улсын дундаж цалингаас **248,000** төгрөгөөр илүү байна.

ААНБ-ын төлсөн **НДШ-ийн дүн: 208,801,554,545 төгрөг ба 150 хүүхдийн багтаамжтай 104 цэцэрлэгийг** барьж байгуулах өртөгтэй байхаар байна

Гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын 2020 оны татвар төлөлт нь **1,228,822,314,724 150 хүүхдийн багтаамжтай 614 цэцэрлэгийг** барьж байгуулах өртөгтэй байхаар байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН БОДЛОГО

- **10 их наядын цогц** төлөвлөгөөний хэрэгжилтийн явцаас
- Ажлын байрыг дэмжих **3 хувийн хүүтэй зээлийг олгож эхэллээ**
- **Халамжаас хөдөлмөрт шилжиж**, ядуурлыг бууруулна
- **Нийгмийн даатгалын цахимжилт**
- **Вакцинжуулалтын** явцын талаар
- **Улсын их хурлын хаврын чуулган** нээлтээ хийв

10 ИХ НАЯДЫН ЦОГЦ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦДААС

“Invest in Mongolia” цахим сэтгүүлийн 3 дугаар сарын дугаарт 2023 оныг дуустал хэрэгжүүлэх “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний талаар мэдээлсэн. Энэ удаагийн дугаарт 10 их наядын цогц төлөвлөгөөний хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хүргэж байна.

АЖЛЫН БАЙРЫГ ДЭМЖИХ 3 ХУВИЙН ХҮҮТЭЙ ЗЭЭЛИЙГ ОЛГОЖ ЭХЭЛЛЭЭ

Монгол Улсын Засгийн газрын “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан эдийн засгийн гол хөдөлгөгч хүч, ажлын байрыг бүрдүүлэгч жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааг сэргээх, ажлын байрыг хадгалах, дэмжих, зорилготой 2 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий “Ажлын байрыг дэмжих 3 хувийн хүүтэй зээл” олгогдож эхэллээ. Бизнес эрхлэгч иргэнд 50 сая хүртэл, НӨАТ төлөгч аж ахуйн нэгжид 500 сая хүртэл төгрөгийн зээлийг жилийн 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатайгаар олгож байна.

Одоогийн байдлаар нийт 12 арилжааны банкаас Төрийн банк, Хаан банк, Голомт банк, Хас банк, Кредит банк зээлийг олгож, бусад банкууд зээлийн хүсэлтийг хүлээн авч байна. 03 дугаар сарын 10-аас 26-ны байдлаар банкууд 1208 зээлдэгчид 75.3 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Судалгаагаар нийт 500-600 тэрбум төгрөгийг 20-25 мянган иргэнд олгох тоо гарчээ. Харин ААН-үүдийн хувьд 500 сая хүртэл төгрөгийг олгож, хэрэв тухайн ААН хүсвэл, шаардлагатай бол, мөн барьцаа хөрөнгө хүрэхгүй нөхцөлд авах зээлийнхээ 60 хүртэлх хувь дээр Зээлийн батлан даалтын сангаас буюу төрөөс баталгаа гаргуулаад арилжааны банкуудаас авах юм.

Энэ 2 их наядын нэг их наяд нь тухайн арилжааны банкны эх үүсвэрээс зээл олгогдох ба ерөнхий гэрээг Сангийн яам, ХХААХҮЯ, Монголбанк, Зээлийн батлан даалтын сан, банкууд хамтран байгуулж хамтран ажиллана.

Ажлын байрыг дэмжих зээл нь нийт 9 хувийн хүүтэй бөгөөд 3 хувийн хүүг аж ахуйн нэгжүүд төлж, үлдсэн 6 хувийн хүүг Засгийн газар хариуцаж иргэд, аж ахуйн нэгжүүдээ дэмжиж байна.

ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ ШИЛЖИЖ, ЯДУУРЛЫГ БУУРУУЛНА

ЭНЭ ОНД 5000 ЗАЛУУСЫГ СУРГАЖ, АЖИЛТАЙ, ОРЛОГОТой БОЛОХОД НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛНЭ.

Монгол Улсад 15 ба түүнээс дээш насны 2.1 сая хүн бий. Тэдний 994 мянга эрэгтэй, 1.1 сая нь эмэгтэй байна. Монгол Улсад 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар хөдөлмөрийн насны ажил, хөдөлмөр эрхлээгүй 58 841 залуус байна. Ажилгүй иргэдийн 58 хувь нь хүнсний эрхийн бичиг авч байна. Гэтэл 20-30 мянган ажлын байр эзнээ хүлээсээр л байна. Мөн ажил олгогчид залуус тогтвор суурьшилтай ажиллахгүй байна гэж байнга хэлдэг.

Иймд 3 дугаар сарын 10-нд Засгийн газрын ээлжит хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-ний хүрээнд халамжаас хөдөлмөрт шилжиж, ядуурлыг бууруулах үүднээс 18-34 насны залуучуудыг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх 1 сарын вакуумжсан, 1 сая төгрөгийн тэтгэлэгтэй сургалтад хамруулах "Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх" төслийг баталлаа.

Ирэх сараас ажилгүй залуучуудыг сонгон шалгаруулж, эхний ээлжид 500 залууг тэтгэлэгт сургалтад хамруулахаар болсон. Цаашлаад энэ тоо 1000 болж өснө. Энэ загвар амжилтад хүрвэл сард 5000 хүртэл тооны хүнийг сургана.

Хувь хүний хөгжил, ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрт бэлтгэх, эх оронч үзэл төлөвшлийн зэрэг 4 төрлийн сургалтыг явуулна. Мэргэжил олгох сургалт явагдахгүй бөгөөд мэргэжил эзэмшсэн залуучуудыг төгссөний дараа ажлын байраар хангах, дахин мэргэших, эсвэл мэргэжил эзэмшээгүй залуучуудыг мэргэжил эзэмших хүсэлтэй, ажил хөдөлмөрт дуртай болох, сурахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

Өөрөөр хэлбэл, төсөлд хамрагдсан иргэдийг ажлын байранд зуучлах, тэдний хүсэл сонирхлоос хамааран жижиг зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулах, мэргэжлийн болон

үйлдвэрлэл дээрх сургалтад хамруулах, ажлын байраар хангасан ажил олгогчийг дэмжих зэрэг ажлыг хэрэгжүүлэх юм.

Сургалтын хугацаа нэг сар байх бөгөөд залуучуудыг тусгай сургалтын газарт байрлуулж, цогц сургалтад хамруулна. Тэгэхээр энэ хугацаанд тусгаарлагдах буюу ажил, хөдөлмөр хийх хүсэл, сонирхолтой үе тэнгийн залуучуудтайгаа бие биеэсээ суралцах, хамтдаа хөгжих боломжтой орчинд байрлуулна.

Төсөлд хамрагдсан залуусыг нэг жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажилтай болгосон ажил олгогч, ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцсон нэг жилийн Нийгмийн даатгалын шимтгэл /эрүүл мэндийн даатгалын шимтгэл орохгүй/-тэй тэнцэх нэг удаагийн нөхөн олговор олгохоор төлөвлөв. Үүнд шаардагдах хөрөнгийг 2022 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байх юм.



АЖЛЫН БАЙР ДЭМЖИХ ЗЭЭЛ



3%
ХҮҮ



иргэнд
50₮ сая




500₮ сая



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Нийгмийн даатгалын ДЭВТЭР ЦАХИМЖЛАА



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЦАХИМЖИЛТ

www.ndaatgal.mn

КОВИД-19-ийн үед e-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн цахим системээс иргэд хамгийн олон хандаж мэдээлэл авсан топ 10 үйлчилгээний нэг нь Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ байсан.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭ ЦАХИМЖЛАА:

- Нийгмийн даатгалын дэвтрийг цахим хэлбэрт шилжүүлээ.
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 1995-2005 оны хугацаат тайланг бүрэн цахимжууллаа
- Тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөх үйлчилгээг цахимжууллаа
- Сайн дурын даатгалд хамрагдах үйлчилгээг гар утсаараа авах боломжийг бүрдүүлээ.

Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулснаар даатгуулагч, ажил олгогч байгууллага, байцаагчдын цаг зав, зардлыг хэмнэхээс гадна орон зайнаас үл хамаарч хаанаас ч Нийгмийн даатгалын үйлчилгээ авах бүрэн боломжтой боллоо.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛСНААР:

Иргэн, ААН, байгууллага бүр эрх тэгш, нээлттэйгээр ойлгомжтой, энгийн, чирэгдэлгүй, ил тод, хурдтайгаар төрийн үйлчилгээг цаг хугацаа, цаас хэмнэсэн байдлаар авахаас авахаас гадна санал, дүгнэлт өгөх, хянах боломжийг бүрдүүлж,

Төрийн хувьд авлига, хүнд сурталгүйгээр үйлчилгээ үзүүлэх, хуурамч бичиг баримтын асуудлыг таслан зогсоож, Big data буюу том хэмжээний мэдээллийн сан бүрдэж, түүнд суурилж төрийн бодлого шийдвэрүүд илүү оновчтой гарна.

Нийгмийн даатгалын дэвтэр цахим хэлбэрт шилжсэнээр Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд ажил олгогчийн Нийгмийн даатгалын дэвэрт сар бүр бичилт хийж, нийгмийн даатгалын байцаагчаар баталгаажуулалт хийлгэх шаардлагагүй болсноор цаг хугацааг хэмнэсэн, нягтлан бодогчдын ажлыг хөнгөвчилсөн давуу тал үүсэж байна.

Харин аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын сар бүрийн тайланг уламжлалт байдлаар цаасан хэлбэрээр харьяа дүүрэгтээ аваачиж баталгаажуулдаг байдал хэвээр байгаа нь хүндрэлтэй байна. Иймд дараагийн шатанд уг тайлан 100 хувь цахим хэлбэрт шилжсэнээр төрийн үйлчилгээ чирэгдэлгүй, түргэн шуурхай, цаг хугацаа, цаас хэмнэсэн болно.

ВАКЦИНЖУУЛАЛТЫН ЯВЦЫН ТАЛААР

Дэлхий дахиныг хамарсан цар тахалтай тэмцэхийн тулд улс орнууд вакцинжуулалтыг эрчимтэй хийж байна. Монгол Улсын хэмжээнд 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдөр эхэлсэн КОВИД-19 цар тахлын эсрэг дархлаажуулалтын аян төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байна. Одоогийн байдлаар улсын хэмжээнд нийт 376,373 /04 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар/ хүн вакцинжуулалтад хамрагдсан байна.

Хамгийн сүүлийн үеийн мэдээллээс

дурдахад, Монгол Улс олон улсын вакцин хангамжийн "КОВАКС" хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдөр 25,740 тун Пфайзер вакциныг хүлээн авч, хавдрын эмчилгээ хийлгэж байгаа болон эрхтэн шилжүүлсэн иргэдэд хийж эхлээд байна. Мөн БНХАУ-аас худалдан авч буй "Синофарм" компанийн үйлдвэрлэсэн "Вероселл" вакцины эхний ээлжийн 300 мянган тунг 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авсан.

"КОВАКС" нь КОВИД-19 цар тахлын эсрэг

арга хэмжээ болон тусламж үйлчилгээний хүртээмжийг эрчимжүүлэх санаачилга бүхий механизм бөгөөд Тархварзүйн бэлэн байдлын шинэчлэлийн холбоо (CEPI), Вакцин дархлаажуулалтын глобал альянс (GAVI), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO) зэрэг олон улсын байгууллагуудын хамтын удирдлагаар НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), Дэлхийн банк, Европын холбоо, иргэний нийгмийн байгууллагууд, вакцин үйлдвэрлэгчид болон бусад түнш байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөр юм.

ӨНӨӨДРИЙН БАЙДЛААР МОНГОЛ УЛСЫН ХҮЛЭЭН АВСАН ВАКЦИНЫ ТОО ХЭМЖЭЭ:

| № | ВАКЦИНЫ НЭР | ҮЙЛДВЭРЛЭСЭН УЛС | ТОО ХЭМЖЭЭ | ОГНОО | |
|---|----------------------------|------------------|------------|------------|--------------------------------|
| 1 | АстраЗенека / COVISHIELD / | БНЭУ | 150,000 | 2021.02.22 | БНЭУ-ын Засгийн газар |
| 2 | Синофарм / VERO CELL / | БНХАУ | 300,000 | 2021.02.22 | БНХАУ-ын Засгийн газар |
| 3 | АстраЗенека /ОКСФОРД / | БНСУ | 14,400 | 2021.03.12 | "КОВАКС" хөтөлбөр |
| 4 | Спутник - V | ОХУ | 10,000 | 2021.02.27 | "Монгол Эм Импекс Концерн" ХХК |
| 5 | Пфайзер | АНУ | 25,740 | 2021.03.26 | "КОВАКС" хөтөлбөр |
| 6 | Синофарм / VERO CELL / | БНХАУ | 300,000 | 2021.04.02 | Монгол Улсын Засгийн газар |

ВАКЦИНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ:

| № | ВАКЦИНЫНЭР | ТООХЭМЖЭЭ | ОГНОО |
|---|-------------------|-----------|----------------------------|
| 1 | Спутник - V | 300,000 | 4 дүгээр сарын эхээр |
| 2 | АстраЗенека | 300,000 | 4 дүгээр сарын эхээр |
| 3 | Синофарм VEROCELL | 900,000 | 4 дүгээр сарын 15, сүүлээр |
| 4 | АстраЗенека | 97,600 | 4 дүгээр сарын сүүлээр |

ВАКЦИНЖУУЛАЛТЫН 8 ҮЕ ШАТ:

- Хариу арга хэмжээний баг /ЭМ, УОК, НОК, ДОК, ХХЕГ, ГЕГ, ОБЕГ, МХЕГ, ЦЕГ/ 47,136
- Үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх шаардлагатай салбар 53,327
- Худалдаа үйлчилгээний салбар 40,000
- Бүх шатны боловсролын салбарын ажилчид 45,300
- 50-64 насны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд 189,372
- 65+ насны болон эрхтэн шилжүүлэн суулгасан иргэд 66,890
- 18-25 насны иргэд 143,000
- 25-49 насны иргэд 558,000

VACCINE
COVID-19

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХАВРЫН ЧУУЛГАН НЭЭЛТЭЭ ХИЙВ

Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулган 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эхэллээ. Хаврын ээлжит чуулган урьд жилүүдийнхээс эрт эхэлж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд анхаарч, хүний эрх, нийгэмд шударга ёс тогтоох шүүх, хуулийн байгууллагуудын хараат бус байдлыг хангах, улс орны хөгжил, нийгмийн амьдралд томоохон өөрчлөлт авчрах зэрэг нэн чухал хуулийн төслүүдийг хэлэлцэхээр чуулах юм.

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” тогтоолыг 2020 оны намрын чуулганы төгсгөлд Улсын Их Хурал баталж, нийтдээ 50 хуулийн төслийг хэлэлцэхээр дараалал тогтоосон.

Чуулганаар хэлэлцэх асуудлуудын хүрээнд Үндэсний хөгжлийн газрын хувьд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

“МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж байна.

“МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫН ҮНДЭСНИЙ ЗОРИЛТОТ ТҮВШИН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгын Үндэсний зорилгот түвшин, шалгуур үзүүлэлт”-ийн төслийг боловсруулж, Тогтвортой хөгжлийн Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛИЙН ТӨСӨЛ

Засгийн газраас өгсөн чиг үүргийн дагуу Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, тэдгээрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх ажлыг гүйцэтгэж байна

ВЕБИНАР БОЛОН АРГА ХЭМЖЭЭ

- ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫГ** ХЯНАН ХЭЛЭЛЦЭВ
- “МАРГААНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМ” сэдэвт олон улсын цахим хурал боллоо
- Хөрөнгө оруулалтын төслүүдээ сурталчилна
- **МОНГОЛ УЛС ДАХЬ АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ:** Монгол Улсын 2021 оны хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл
- **МОНГОЛ УЛС ДАХЬ БРИТАНИЙН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ БОЛОН PwC КОМПАНИ:** Давхар татварын гэрээний талаарх цахим хэлэлцүүлэг

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГА **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГЫГ** ХЯНАН ХЭЛЭЛЦЭВ

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ) 2021 оны 3 дугаар сарын 17-19-ний өдөр Монгол Улсын худалдааны бодлогыг хянан хэлэлцсэн. Хуралдаанд оролцож байгаа монголын талын төлөөлөгчдийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг тэргүүлж, хуралдааны даргаар Исланд Улсын Элчин сайд Хералд Аспелүнд, хэлэлцүүлэгчээр Малайз Улсын Элчин сайд Рашиди Саид нар ажиллаж байна.

Гишүүн улс орнууд Монгол Улс нээлттэй, чөлөөт худалдааны бодлого хэрэгжүүлж, олон талт худалдааны тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулж байгааг үнэлээд, Засгийн газар эдийн засгийг төрөлжүүлэх, худалдааг хөнгөвчлөх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр идэвхтэй бодлого баримталж ирснийг онцолж байв. Үүний зэрэгцээ хөрөнгө оруулалтын орчин, худалдааны бодлого зохицуулалтын ил тод байдлыг хангах, эдийн засаг дахь төрийн оролцоо мөн худалдаан дахь техникийн зохицуулалтыг сайжруулах, боловсронгуй болгох зэрэгцээ шаардлага байгааг тэмдэглэв. Монгол Улсын худалдааны бодлогын талаарх тайлантай холбогдуулан ДХБ-ын гишүүн 16 улсаас 300 гаруй асуулт урьдчилан ирүүлснээс гадна хуралдааны үеэр 21 улсын төлөөлөл үг хэлэв.

Дэлхийн худалдааны байгууллага Монгол Улсын худалдааны бодлогыг өмнө 2005, 2014 онуудад тус тус хянан хэлэлцэж байсан болно.

DISPUTE
PREVENTION
MECHANISMS

“МАРГААНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМ”

СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЦАХИМ ХУРАЛ БОЛЛОО

Колумбия Их Сургуулийн дэргэдэх тогтвортой хөрөнгө оруулалтын төвөөс /COLUMBIA CENTER ON SUSTAINABLE INVESTMENT/ “МАРГААНААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМ” /DISPUTE PREVENTION MECHANISMS/ сэдэвт олон улсын цахим хурлыг 2021 оны 3-р сарын 9-11-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг цахим хуралд Монгол улсын зүгээс “Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем- SIRM”-ийг танилцуулж, харилцан туршлага солилцлоо.

Улс орнууд омбудсман, яам хоорондын хороо /interministerial committee/, маргаан шийдвэрлэх хороо, зөвлөл зэргээр маргаанаас урьдчилан сэргийлэх механизмыг хэрэгжүүлж байна. Эдгээр маргаанаас урьдчилан сэргийлэх байгууллагууд нь худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой гомдлыг хүлээн авч, төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор шийдвэрлэдэг бөгөөд нарийн бичиг, ажлын алба зэрэг төрийн байгууллагуудын уялдааг хангах чиг үүргийг Худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан яам, агентлагууд нь хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл” нь маргаанаас урьдчилан сэргийлэх үндсэн механизм бөгөөд Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэн авч, төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор шийдвэрлэж байна. Та хөрөнгө оруулагчийн гомдлын цахим систем SIRM-ын талаар дэлгэрэнгүй мэдээллийг www.nda.gov.mn хуудаснаас хүлээн авч үзээрэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭЭ СУРТАЛЧИЛНА

Эдийн засгийн хямралын үед үндэсний үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, төсөл хэрэгжүүлэгчдийн хэрэгжих боломж өндөртэй, хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийг хөрөнгө оруулагчдад танилцуулан сурталчлах үүднээс Үндэсний хөгжлийн газрын санаачлагаар 2021 оны 5 дугаар сард “INVEST IN MONGOLIA – TOKYO 2021” Япон-Монголын бизнес уулзалт, 6 дугаар сард “INVEST IN MONGOLIA – SEOUL 2021” Солонгос-Монголын бизнес уулзалтыг

Монгол Улсын ГХЯ, Монгол Улсаас Япон Улсад суугаа ЭСЯ, Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ, Дэлхийн банк группын Олон улсын санхүүгийн корпораци болон бусад байгууллагуудтай хамтран цахимаар зохион байгуулах гэж байна.

Монгол Улсын гадаадын хөрөнгө оруулалтын орчин, бодлогын шинэчлэл, хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгаа, үйлчилгээний талаарх мэдээллийг Япон, Солонгосын хөрөнгө оруулагчдад танилцуулахаас гадна стратегийн ач холбогдол бүхий 100 төслүүдээс түүвэрлэн, мөн түүнчлэн хувийн хэвшлийн боломжит төслүүдээс танилцуулан сурталчилна.

МОНГОЛ УЛС ДАХЬ АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ:

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫ МЭДЭГДЭЛ

Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамнаас Америкийн Нэгдсэн Улсын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад зориулан эрхлэн гаргахаар бэлтгэж буй “Монгол Улсын 2021 оны хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл”-д мэдээлэл өгөх хүрээнд 3 дугаар сарын 12-ний өдөр Үндэсний хөгжлийн газраас Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Дашдэмбэрэл болон Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Батчимэг, Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамнаас Эдийн засаг, Худалдааны хэлтсийн худалдааны ахлах мэргэжилтэн Майкл Ричмонд гэсэн бүрэлдэхүүнтэйгээр цахим уулзалт зохион байгуулсан билээ.

Тус уулзалтад талууд Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны талаар санал бодлоо солилцон, Үндэсний хөгжлийн газраас 2021 онд хөрөнгө оруулалтын орчны шинэчлэл хийх ажлын хүрээнд хийгдэхээр төлөвлөж буй ажлын төлөвлөгөөг танилцууллаа.

Мөн тус Элчин сайдын яамнаас бэлтгэсэн Монгол Улсын 2020 оны хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэлд тусгасан гадаадын хөрөнгө оруулагчдын газар ашиглах эрхийн тухай зөрүүтэй мэдээллийг хэлэлцэн зөрүүг арилгаж, үнэн зөв мэдээллийг хүргүүллээ. Уг Монгол Улсын 2021 оны хөрөнгө оруулалтын орчны мэдэгдэл нь 2021 оны 8 дугаар сарын дунд үеэс олон нийтэд цацагдах төлөвлөгөөтэй байгаа гэж мэдээлэв.

МОНГОЛ УЛС ДАХЬ БРИТАНИЙН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ БОЛОН PwC КОМПАНИ:

ДАВХАР ТАТВАРЫН ГЭРЭЭНИЙ ТАЛААРХ ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Монгол Улс дахь Британийн Элчин Сайдын Яам нь PwC компанитай хамтарч “Их Британи, Монгол Улсын хооронд байгуулагдсан давхар татварын гэрээний үр ашиг, хэрэгжилт” сэдвээр Монгол Улсын төрийн байгууллагуудтай 3 дугаар сарын 16-ны өдөр цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан ба тус хэлэлцүүлэгт Үндэсний хөгжлийн газраас Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Дашдэмбэрэл болон Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Батчимэг нар оролцсон билээ.

Уг хэлэлцүүлгийг Британийн Цог Жавхлтан Хатан хааны Элчин сайд Филип Малон нээж үг хэлсний дараагаас PwC компани нь Их Британи, Монгол Улсын хооронд байгуулагдсан давхар татварын гэрээний үр ашиг, хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар, уг гэрээ нь Британи болон Монгол Улсын хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэхэд хэр ач холбогдолтой болохыг тайлбарласан үр өгөөжтэй хэлэлцүүлэг болж өндөрлөв.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ОРЧИН

Худалдаа, хөрөнгө оруулалтын асуудал нь салшгүй уялдаа холбоотой, нэгдмэл ойлголтын хүрээнд үйл ажиллагаа нь явагддаг бөгөөд эдийн засгийн бүх салбарт бодлогын болоод зохицуулалтын түвшинд оролцож байдаг.

Монгол Улс нь хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн гадаад орчны хувьд үндэсний хууль тогтоомжоор хамгаалагдахаас гадна олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцоор баталгаажсан байдаг. Жишээлбэл, "Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай" Вашингтоны конвенц болон "Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай" Сөүлийн конвенцод тус тус нэгдэн орсон билээ. Мөн 43 улстай Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг, 25 улстай давхар татвараас чөлөөлөх хэлэлцээрийг тус тус байгуулсан. Мөн одоо байгуулсан болон ирээдүйд байгуулах гэрээнд талуудын эрх, ашгийг ижил хэмжээнд оруулж, харилцан ашигтай,

тэнцвэртэй хэлэлцээр байгуулах зорилгоор Засгийн газраас "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийн загвар"-ыг 2019 онд баталсан. Үүнтэй холбогдуулан Гадаад харилцааны яам, Үндэсний хөгжлийн газар хамтран "Арга хэмжээний төлөвлөгөө"-г баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагын гишүүн орноор 1997 онд элсэж орсноор дэлхийн 164 гишүүн оронтой үндэстний нэн тааламжтай нөхцөлөөр буюу тарифын хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр худалдаа хийх боломжоор нээгдсэн байдаг.

Мөн 2016 онд "Монгол Улс болон Япон улс хоорондын эдийн засгийн түншлэлийн тухай хэлэлцээр"-ийг байгуулж гарал үүслийн шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг импортын гаалийн татварыг тэглэх, эсхүл үе шаттайгаар бууруулах замаар тодорхой хугацааны дараа тэглэх нөхцөл бүрдэн, хэрэгжиж эхлээд байна. Уг хэлэлцээрийн

хүрээнд Монголын талаас 5700 орчим нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнийг Япон улсын зах зээлд экспортолж, Япон улсаас 9300 орчим нэр төрлийн барааг импортлох жагсаалт батлагдсан.

Өнгөрсөн онд "Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр"-т нэгдэж, уг хэлэлцээрийн 7 дахь гишүүн болоод байна. "Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр"-т нэгдсэнээр Монгол Улс нь Ази, Номхон Далайн Худалдааны Хэлэлцээрийн зургаан гишүүн улс руу нийтдээ 10,667 нэр төрлийн бараанд 5-100 хувийн татварын хөнгөлөлт эдлэх боломж нээгдэж, дэлхийн болон бүс нутгийн нийлүүлэлтийн сүлжээнд холбогдож, хөрөнгө оруулалт татахад илүү таатай нөхцөл бүрдэж байна. Мөн Европын Холбооны Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GPS+)-ийн хүрээнд Монгол Улсаас гарал үүсэлтэй 7200 бараа бүтээгдэхүүнд гаалийн тарифын хөнгөлөлт эдэлдэг.

Монгол Улс 2020 оны байдлаар 149 улстай 12.9 тэрбум ам.долларын гадаад худалдааг хийсэн. Үүнээс 7.6 тэрбум ам.долларын бараа, бүтээгдэхүүний экспортыг 75 улсад, 5.3 тэрбум ам.долларын импортын бараа, бүтээгдэхүүнийг 142 орноос оруулжээ. Үүнийг бүтээгдэхүүнээр нь задалж үзвэл экспортын 69.4%-ийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн, 23.6%-ийг үнэт болон хагас үнэт чулуу, үнэт металл, импортын 20%-ийг машин, механик, тоног төхөөрөмж, 19.2%-ийг эрдэс баялгийн бүтээгдэхүүн эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад худалдааны статистик мэдээлэл нь Монгол Улсын эдийн засгийг геологи, уул уурхай, түүхий эдийн бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай байгааг батлан харуулсаар байна.

Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх зорилгоор 2021 оны 01 дүгээр сарын 29-нд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 1.Боловсруулах аж үйлдвэр, 2.Хүнс, хөдөө аж ахуй, 3.Эрчим хүч, 4.Аялал жуулчлал, 5.Жижиг дунд үйлдвэрлэл, 6.Тээвэр, логистик, 7.Бүтээлч үйлдвэрлэл, мэдээлэл, технологийг тэргүүлэх чиглэл болгон зарласан.

Бид дээрх гадаад орчны таатай нөхцөл, боломжийг бүрэн хэмжээнд ашиглах зорилгоор дотоодын хууль эрх зүйн орчныг сайжруулах, "Худалдааны тухай хууль"-тай болох, Худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтыг нэгдсэн байдлаар уялдуулж, хангах чиг үүрэг бүхий тогтвортой бүтцийг бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн гадаадын банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчдын

сонирхлыг татаж, шалгуурт нь тэнцэх хэмжээнд төслийг хөгжүүлж, бэлэн байдлыг хангах, олон улсын стандартад нийцсэн бараа, бүтээгдэхүүнийг экспортлох хөрөнгө санхүү, хүний нөөцийн болоод технологийн чадавхтай хувийн хэвшлийг бий болгох ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Мөн хөрөнгө оруулалт, экспорт, жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилготой тус тусдаа хэрэгжиж байгаа олон төсөл, хөтөлбөрүүдийн хоорондын уялдааг хангах, нэгтгэх, үйл ажиллагааг илүү сайжруулж эдийн засагт бодитоор үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалтын бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Н.ДАШДЭМБЭРЭЛ



ОНЦЛОХ САЛБАР

ЗАГАС ҮРЖҮҮЛГИЙН САЛБАР ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОЛОМЖ



Монголын Загас усны амьтдын үржүүлгийн холбооны Тэргүүн, Загас судлаач Г.БААСАНЖАВ

Загас усны экологийн тогтолцооны чухал хэсэг болох бөгөөд уг тогтолцоог бүрдүүлэгч хэсгүүдийн тэнцвэрт харьцааг зохицуулагчийн үүрэг гүйцэтгэнэ. Усны чанарын нэн нарийн мэдэрдэг соргог илтгэгч (индикатор) нь загас юм.

Загас бол тэжээллэг чанар өндөртэй, хөгжиж буй орнуудын хүн амын хоолны чухал хэсгийг бүрдүүлдэг ба загас үржүүлгийн аж ахуй нь хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, орон нутгийн хөгжилд тухайлбал нөхөрлөл, өрхийн үйлдвэрлэлийн хэлбэрээр аж ахуй эрхэлж тогтвортой амьжиргааг дэмжихэд чухал хувь нэмэр оруулдаг. Хүн амыг загас, загасан бүтээгдэхүүнээр хангах нь махыг орлох, хүнсний нэр

төрлийг олшруулах төдийгүй үнэт уураг, өөх тос, витаминаар хангаж байдаг.

Дэлхий нийтээр далай тэнгисээс олборлох загас агнуурын тоо хэмжээ хэтэрч, нөөц багассан энэ үед далайд гарцгүй 2 дах том нутаг дэвсгэртэй манай улсын хувьд загас үржүүлгийн аж ахуйг хөгжүүлэн эдийн засгийг төрөлжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүнийг бүтээх, махыг орлох, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийн нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм. Монгол улсыг дан ганц уул уурхай дээр суурилсан эдийн засагтай гэж үзэх, зөвхөн тухайн салбарт анхаарах хандлага гаднын судлаачдын дунд байдаг. Өнөөдөр Монгол Улсад загасны аж ахуй нь жижиг салбар гэж тооцогддог гэсэн хэдийн ч сүүлийн хэдэн жилийн турш Монголын Засгийн газар үүнийг хөгжүүлэх арга хэмжээ авч байна.

Тухайлбал 2014-2016 онд НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага болон Монгол улсын Засгийн газар, ХХААХҮ Яамтай хамтран “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх нь” TCP/MON/3501 төслийг хэрэгжүүлж жишиг загасны аж ахуй байгуулахад зөвлөн чиглүүлсэн.

Мөн Монгол улсын Засгийн газраас баталсан загас үржүүлгийн аж ахуй

байгуулахыг дэмжих “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих” хөтөлбөр болон үржүүлгийн аж ахуйгаар бүтээгдэхүүн болон гарах загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих “Эрүүл Монгол- Эрүүл Хүнс” хөтөлбөрүүд жижиг дунд бизнес эрхлэгчдэд загасны аж ахуй, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх боломжийг олгосон.

Хөдөө аж ахуйн салбарт хийгддэг ГШХО-ын мөнгөн дүн ихэнх тохиолдолд бусад салбарынхаас харьцангуй бага байдаг. Гэсэн хэдий ч зарим гол чухал хөрөнгө оруулалт тухайн орны ХАА-н үнэ цэний сүлжээг эргүүлэхүйц хэмжээний нөлөөг үзүүлж болно. Хөдөө аж ахуйн салбар болон хөдөө аж ахуйн бизнесийн ажлын байрны тоо, бүтээмж, орлого дорвитой нэмэгдэх нь ядуурлыг бууруулж, хүнсний баталгаат байдлыг хангахад чухал үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын орчныг улам эерэг болгох, дэд бүтцийн хангамж, хөдөлмөрийн зах зээлийг бэхжүүлэх, ирээдүйтэй салбаруудад бодлогын дэмжлэг үзүүлэх тал дээр Засгийн Газар анхааран ажиллавал хөрөнгө оруулалтыг урт хугацаанд тогтвортойгоор татах Монгол Улсын чадамж үлэмж дээшлэх боломжтой.



ЗАГАСНЫ АЖ АХУЙ ЭРХЭЛЖ БУЙ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР ДУРДАХАД

Монгол Улсад загасыг зохиомлоор үржүүлэн тоо толгой нь хорогдож байгаа загасны тоо толгойг хамгаалах, салбарын боловсон хүчнийг бэлтгэхэд, судалгаа, дадлагын баазыг бий болгох зорилгоор байгуулагдсан “Жижиг горхи” ТББ нь 2010 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Жижиг загасны аж ахуй нь УБ хотоос 60км-т орших Төв аймгийн Эрдэнэ сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагааг эхлүүлсэн. ТББ нь 2011 онд НҮБ-ын Даян дэлхийн Байгаль орчны сангийн жижиг төсөл хөтөлбөрт хамрагдаж “Байгалийн усан санг цөөрмийн зориулалтаар ашиглан загас өсгөн үржүүлэх төсөл”-г (Fish breeding in natural pond project, The GEF Small Grand Program, United Nations of Mongolia) хэрэгжүүлсэн. Төслийн үр дүнд Туул голын дэргэдэх хуучин салааны гольдролыг ашиглан усан сан байгуулж тус сав газрын цэвэр усны нөөцийг нэмэгдүүлэх ялангуяа усны экосистемийг хамгаалах, улмаар загасыг зохиомлоор үржүүлэн өсгөх ба байгалийн аясаар үржих боломжийг хангах, хүрээлэн буй орчныг хамгаалж, судалгаа шинжилгээний баазын суурийг эхлүүлсэн.

ТББ-ийн үүсгэн байгуулагч Г.Баасанжав нь аквакалчур салбарыг хөгжүүлэх, загас үржүүлгийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн эрхлэгчдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэн хамтран ажиллах, салбарын эрх зүйн орчинг тодотгон бүрдүүлэхэд хэрэгцээ шаардлагатай судалгаа хийх, олон талт хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой Монголын Загас усны амьтан үржүүлгийн холбоог 2018 онд байгуулсан. Холбооны бодлогыг тодорхойлогч тэргүүлэгч гишүүд нь загас, усны амьтан ургамал судлаач, биологичдоос бүрдсэн холбоо билээ.

ХОЛБОО БАРИХ: Баянзүрх дүүрэг, 25-р хороо,
Шинэ дөл оффис, 404 тоот Улаанбаатар 12274
ИМЭЙЛ: mongolianaquaculture@gmail.com



АМЖИЛТЫН ТҮҮХ PwC КОМПАНИ

Энэ дугаарт гадаад, дотоодын компаниудад аудит, баталгаажуулах үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ, татварын болон хууль эрх зүйн үйлчилгээ, хүний нөөцийн үйлчилгээний цогц шийдлийг санал болгодог PwC Mongolia / ПидабальюСи Монгол компанийг онцолж байна.

PwC-ийн зорилго нь нийгэмд итгэлцлийг бий болгож улмаар цогцлоон байгуулах, чухал асуудлуудыг шийдвэрлэхэд оршино. Улам нарийн төвөгтэй болж буй өнөөгийн нийгэмд бид хөрөнгийн зах зээл, татварын систем эсвэл эдийн засгийн систем байхаас үл хамааран нийгэм, нийгэмд үр өгөөжөө өгдөг нарийн төвөгтэй системүүдийг ажиллуулах, тэдэнд дасан зохицох, өөрчлөгдөж хөгжихөд нь тусалдаг.

“” **Үндэсний хөгжлийн газраас сар бүр хөрөнгө оруулагчдад хүргэх мэдээллийн тусгай зочин.**



ШАУКАТ ТАПИА
PwC Аудит ХХК-ийн Партнер

PwC Global сүлжээ болон түүний түүхийн талаар манай уншигчдад танилцуулахгүй юу?

PwC нь 1998 онд “PriceWaterhouse болон Coopers & Lybrand” компаниудын нэгдлээс үүсэж байгуулагдсан бөгөөд XIX зууны үеэс үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлж байсан арвин түүхтэй. Нягтлан бодох бүртгэлийн энэ хоёр компани хоёулаа 1800-аад оны дунд үед Лондон хотноо үүсгэн байгуулагдсан ба энэхүү түүхэн хугацааны 120 гаруй жилд нэг харилцагчтай тууштай ажилласан. Тухайлбал, 1896 оноос хойш “Barclays” (Британийн хоёр дахь том банк.) аудитортай хамтран ажиллаж ирсэн.

Дэлхийн 155 улсад оффистой, 284,000 гаруй ажилчидтай PwC сүлжээ нь дэлхийн тэргүүлэх мэргэжлийн үйлчилгээний дөрвөн томын эгнээнд багтдаг. Бид байгууллага, хувь хүмүүст баталгаа, татвар, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар тэдний эрэлхийлж буй үнэ цэнийг бий болгоход нь тусалдаг.

Бид аудитын чиглэлээр нэгдүгээрт жагсаж, зөвлөх үйлчилгээний 65%, татварын зөвлөх үйлчилгээний 80%-ийг тус тус хангасан. Манай бизнес жил бүр өссөөр байна. 2020 оны санхүүгийн жилд бид дэлхийд 63,053 хүнийг шинээр ажилд авсан, үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 3%-иар өсөж, 43 тэрбум доллар хүрсэн.

PwC Mongolia хэрхэн үйл ажиллагаа явуулаг вэ, ямар үйлчилгээ санал болгодог вэ?

ПидабальюСи Монгол нь Монгол Улсад бүрэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд манай PwC-ийн 3 байгууллагын 90 гаруй ажилтантай. ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК нь аудитын лицензээ 2010 оны 4-р сард авч, 2010 оны 9-р сард албан газраа албан ёсоор нээсэн.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК нь дараах бүх төрлийн үйлчилгээг санал болгодог. Үүнд:

- Баталгаажуулалт (санхүүгийн тайлангийн аудит, санхүүгийн болон нягтлан бодох

бүртгэлийн зөвлөмж, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн ерөнхий зарчмуудын (GAAP) тодорхойлолт ба АНУ-ын “GAAP” зэрэг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зохицуулалтын үйлчилгээ, актуарийн үйлчилгээ, хеджинг, дотоод аудит, хяналт, гүйцэтгэл, бизнесийн тогтвортой байдал, мэдээллийн технологийн аюулгүй байдал, систем, процессын баталгаажуулалт)

- Баталгаажуулалт, аудитын чиглэлээр бид 70 гаруй ажиллагсадтайгаас хоёр нь гадаад мэргэжилтнүүд бөгөөд 2016 оны 1-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу 33% нь Монгол улсын иргэд хувьцаа эзэмшигчид. ПидабальюСи Монгол нь төмөр зам, банк, уул уурхайн салбарт аудит, татвар, зөвлөгөө өгөх чиглэлээр өргөн туршлагатай, мэргэжлийн үйлчилгээний зах зээлд тэргүүлэгч бөгөөд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн томоохон байгууллагууд, банкнууд, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай томоохон группүүдтэй харьцдаг.

- Манай баталгаажуулалтын хамт олон АССА зэрэгтэй 15 ажилтан, Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй 14 ажилтан, Монгол Улсын Насан туршийн МНБ-ын эрхтэй 9 ажилтан ба аудиторын 8 тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Мөн бид ажилчдадаа АССА хөтөлбөрийг судлах шаардлага тавьдаг. Нийт аудит, баталгаажуулалтын ажилтны 70-аас дээш хувь нь олон улсын болон монголын мэргэшсэн зэрэгтэй.

Та Монголд анх хэзээ ирсэн бэ? Таныг ирэх үеийн Монголын хөгжил одоогийнхтой харьцуулахад ямар болсон бэ? Сэтгэгдлээсээ хуваалцана уу?

Би Монголд 11 жилийн өмнө ирж байсан. Тухайн үед Монгол Улсад уул уурхай ид хөгжин цэцэглэж, том төслүүд эхэлсэн үе байсан. Тухайлбал Эрдэнэс Таван толгой, Оюутолгой гэх мэт том төслүүд эхэлж, гадаадын хөрөнгө оруулалтууд ар араасаа хөвөрч эдийн засгийн өсөлт 17 гаруй хувийн өсөлттэй болж гадаад улс орнуудын

анхаарлын гол төвд байсан. Харин манай компани дөнгөж байгуулагдаад үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд би Канадаас ирсэн өдрөөсөө л харилцагчийн үйлчилгээний ажилдаа шууд ханцуйгаа шамлан орж байсан санагдана.

Өмнөх 10 жилтэй харьцуулахад МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн. Монголд PwC байгуулагдаад 10 жил болсон. Өнөөдрийг хүртэл танайх аудитын тэргүүлэгч компани байсаар ирсэн. Танайх байгууллагын амжилтын нууц юу вэ?

Бидний тууштай баримталдаг зарчим нь үйлчилгээнийхээ чанарыг ямагт эрхэмлэдэг. Чанараараа хаа ч тэргүүлэх ёстой гэж үздэг. Бидний итгэл үнэмшил бол өөрсдийнхөө үзүүлж байгаа үйлчилгээнд илүү анхаарах явдал ба энэ нь бидний амжилтын нууц. Нөгөө талаас харилцагчдадаа үнэ цэнийг нэмэгдүүлэх ажлыг хийж чадсан нь хос амжилтын тулгуур гэж бас ойлгож болно.

Ирэх 12 сард PwC Mongolia

хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүд юу вэ?

• **Ирэх арван хоёр сарын хугацаанд бид хэд хэдэн тэргүүлэх чиглэлд анхаарлаа төвлөрүүлнэ:**

• **ЧАНАР:** Цар тахлын улмаас үүссэн тодорхойгүй байдал нь байгууллагуудад итгэх итгэл, мэдээлэлд итгэх итгэл, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд илүү их анхаарал хандуулж байна. Бид үзүүлж буй бүх үйлчилгээнийхээ чанарыг сайжруулахад хөрөнгө оруулах явдлыг нэн тэргүүнд бид тавьсан хэвээр байна.

• **АЖЛЫН БАЙР:** Хүмүүсийнхээ ажлын байрыг хадгалах, PwC-ийн ирээдүйн хэрэгцээт ажиллах хүчийг бий болгоход хөрөнгө оруулах явцыг улам үргэлжлүүлэх.

• **АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА САЙН САЙХАН БАЙДАЛ:** Манай хүмүүсийг аюулгүй, тав тухтай байлгах, оффисоос эсвэл гэрээсээ үргэлжлүүлэн ажиллахаас үл хамааран тэднийг хамгаалах үйл явц, технологийг тогтмол байлгаж байх.

• **ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИД:** Үйлчлүүлэгчдэдээ өнөөгийн бизнесийн загваруудаа эргэцүүлэн бодоход нь дэмжлэг үзүүлж, тэднийг оролцогч талууддаа амжилттай үйлчилж, илүү хүртээмжтэй, тогтвортой дэлхий ертөнцийг бий болгоход туслах замаар үйл ажиллагаагаа дахин эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

• **ИННОВАЦ:** Оролцогч талууддаа хамгийн сайн үйлчилгээг үзүүлэхийн тулд инновацыг удирдах, өргөжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг PwC даяар

хөгжүүлэх. Манай мянга мянган ажилчид 30 улсад PwC Дижитал Лабораториудад үйл ажиллагаагаа явуулдаг ба олон шинэ санааг, шинэ шийдлүүдийг хамтдаа санаачилж, шилдэг туршлагаа хуваалцаж байна.

• **ЧАДВАРЖУУЛАЛД:** Цар тахлын улмаас техник технологи, алсын зайнаас ажиллах явдал улам ихсэж байгаатай холбогдуулан дэлхийн өнцөг булан бүрт байгаа ажилчдынхаа чадварыг дээшлүүлж, чадвараа дээшлүүлэхэд нь туслах явдал улам бүр чухал болж байна. Бид энэ салбарт гурван гаруй жилийн турш гурван тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлсээр байх болно.

• **БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ:** Хүн бүр үнэ цэнэ, хүндлэл, өсөж, амжилтад хүрэх боломжийг мэдэрдэг PwC соёлыг төлөвшүүлэх хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд бид энэ жил дэлхийн өнцөг булан бүрээс есөн том түнштэйгээ хамтран Дэлхийн олон талт байдал болон тэдгээрийг хамруулах зөвлөл (Global Diversity and Inclusion Council)-ийг шинээр байгууллаа.

• **УУР АМЬСГАЛ:** Цаг уурын онцгой байдал өдгөө маш ноцтой байдалд хүрсэн тул хариуд нь бид 2030 он гэхэд хэрхэн "net zero" буюу хүлэмжийн хий тэг түвшинд хүрэх байгууллага болох төлөвлөгөөтэй байгаагаа саяхан зарласан.

COVID-19 танай бизнест хэрхэн нөлөөлж, та бүхэн юуг хийх шаардлагатай байна вэ?

COVID-19 цар тахал нь хүн төрөлхтөн, эрүүл мэнд, эдийн засгийн хямрал байсаар байгаа бөгөөд дэлхийн олон хүмүүсийн, тэр дундаа манай PwC гэр бүлийн гишүүд, тэдний хамаатан садан, найз нөхдийн амьдралд маш гүнзгий нөлөөлсөн. Цар тахлын дэгдэлт болоход энэ урьдчилж таамаглах боломжгүй нөхцөлд бид бүх оролцогч талуудаа дэмжихийн тулд хурдан дасан зохицож чадсан.

ЖИШЭЭЛБЭЛ:

• Хүмүүсийнхээ аюулгүй байдал, аюулгүй байдлыг хамгаалах, ажлын байрыг хадгалах

• Цар тахлын шууд нөлөөг арилгахын тулд үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллах

• Чанартай аудит, татвар, зөвлөх үйлчилгээг саадгүй хүргэх технологийг нэн тэргүүнд ашиглах

• Эрүүл мэндийн тогтолцоог дэмжихээс эхлээд хоол хүнс, эмнэлгийн хэрэгслийг түгээх, онцгой байдлын үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэргээр тусламж

үзүүлэх.

Цар тахал нь хүн бүрт нөлөөлж, манай нийгмийн зарим томоохон сорилтуудыг томруулж, хурдасгаж, нийгмийн оролцоо, ажиллах хүчийг дахин чадваржуулах хэрэгцээ, Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)-ын хөтөлбөр, уур амьсгалын өөрчлөлтийн тулгамдсан асуудал зэрэг салбарт системийн өөрчлөлтийг яаралтай хийх шаардлагатай байгааг харуулж байна.

Монгол Улсад бизнес эхлүүлэх гадаад, дотоодын бизнес эрхлэгчдэд зориулсан өөрийн туршлага дээр үндэслэсэн зөвлөмжүүдийг хүргэвэл?

10 жилийн ойн арга хэмжээнийхээ хүрээнд бид Монгол Улсад хөрөнгө оруулах, бизнес эрхлэх талаар холбогдох мэдээллийг хуваалцах боломжтой болсондоо таатай байна. Монгол улсад бизнес эрхлэх нь 2020 PwC Mongolia-ийн нийтлэл нь Монгол Улсад бизнес эрхлэх сонирхолтой хүмүүст туслах зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд бүх сэдвийг бүрэн авч үзээгүй ч, зарим чухал, өргөн хүрээний асуултуудад хариулах зорилготой.

Бодит байдал дээр тодорхой асуултууд гарч ирэхэд тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрийг лавлах, нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүйн зөвлөгөө авах шаардлагатай болдог. Хэрэв танд Монголд бизнес эрхлэх талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол бидэнтэй холбоо бариарай, эсвэл манай вэбсайтаас татаж авах боломжтой.

ЦАГ ЗАВ ГАРГАСАНД БАЯРЛАЛАА, ТАНАЙ БИЗНЕСТ САЙН САЙХАН БҮХНИЙГ ХҮСЬЕ.



Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны албаны ахлах мэргэжилтэн

С.УНДРАХ



ЦЭВЭР
ХААНА Ч ЦЭВЭР

01 Үндэслэл

Монгол Улсад нийт 506 мянган өрх зөөврийн ус хэрэглэдэг гэсэн тоо байдаг. Өөрөөр хэлбэл 506 мянган муу усны нүх цэвэрлэх байгууламжаар дамжилгүй хөрсөнд, гудамд угаалгын нунтагтайгаа шингэж, цаашлаад 506 мянган модон жорлон хөрс, орчныг өдөр бүр бохирдуулсаар байна.

Хүн ам цөөн, тархан суурьшсан нүүдэлчин ахуйгаас улбаатай манай улсад халуун усны газар, угаалгын газар байгуулах, түүнтэй холбоотой цэвэрлэх байгууламж байгуулах нь өртөг өндөртэй, эдийн засгийн ач холбогдол багатай байгаа учраас өнөөдрийг хүртэл зохистой шийдэл хараахан гараагүй байна.

02 Шийдэл

ТЕХНОЛОГИЙН ШИЙДЭЛ

- Сэргээгдэх эрчим хүч нарны дулаан коллектор болон хаягдал дулааныг дахин ашиглах зарчмаар хосолмол систем байх бөгөөд үндсэн төвийн сүлжээтэй сэлгэн залгагдах зарчмаар ажиллана.
- Хүний бие угаасан усыг дахин боловсруулж, хувцас угаалгад ашиглах ба ариун цэврийн өрөөнд ус ашиглахгүй байхаар төлөвлөх бөгөөд гал тогоо болон ариун цэврийн өрөөнөөс гарсан био хаягдлыг бордоошуулах замаар байгальд хоргүй болгон хөрс сайжруулалтад дахин ашиглана.
- Кассын систем, төлбөр тооцооны систем, карт уншигчийн систем, өөртөө үйлчлэх, хяналтын программ бүхий өөртөө үйлчлэх нийтийн капсул буудал, нийтийн гал тогоо бүхий хялбар дэн буудлын систем багтаасан бие даасан үйлчилгээний төв байна. Үүнд, дэлгүүр, хүлээн авах үйлчилгээ, ачаа бараа хадгалах үйлчилгээ, эмийн сан, ТҮЦ машин болон бэлэн мөнгөний болон худалдааны автомат машинуудаар тоноглогдсон байх ба 24 цагийн турш тасралтгүй ажиллана.

ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТ
ЭРЭЛХИЙЛЖ
БУЙ
МОНГОЛЫН
ГАРААНЫ
БИЗНЕС

БАЙГУУЛАМЖ

- Барилгын хувьд орон нутагт угсрахад бэлэн байхаар зориулсан модулиар загвартай байх бөгөөд улирлаас бага хамааралтай хуурай хийцлэл өндөртэй, дулаан алдагдал бага, өнгө үзэмжээ алддаггүй, мэргэжлийн хүний оролцоо бага шаарддаг угсармал, хөнгөн хийцлэл сонгох бөгөөд гадсан суурьтай хөнгөн ган каркастай байхаар төлөвлөж байна.

САНХҮҮГИЙН ШИЙДЭЛ

- Зээлийн шугам, хөрөнгө оруулалтын шийдэл нэвтрүүлснээр орон нутгийн бизнес эрхлэгчид, санхүүгийн дарамтгүй, төрийн хөрөнгө оруулалт шаардахгүйгээр байгуулах боломжтой.

БИЗНЕСИЙН ШИЙДЭЛ

- Технологи нэвтрүүлэх, үйлчилгээний стандарт тогтоох, ханган нийлүүлэлтийн сүлжээ байгуулах замаар Францэйз бизнесийн загвараар орон нутгуудад байрлуулах бизнесийн загвар боловсруулсан.

03 АЧ ХОЛБОГДОЛ

- Химийн бохирдолтой усыг цэвэршүүлэн дахин ашиглаж, биологийн бохирдолтой бордоо болгож, халуун уснаас гарах хаягдал дулааныг байгууламжийг халаахад ашиглах байдлаар бүх бохирдлыг буцаан эргэлтэд оруулж, төвлөрсөн дэд бүтцийн хөгжлөөс үл хамааран ZERO Waste ажиллах боломжтой төвийн технологийн шийдлийг, бизнесийн ашигтай модельтой хослуулснаар орон нутагт, зам дагуух суурингийн асуудлыг шийдэх боломжтой болно. Энэ нь суурин газрын байгаль орчин, ариун цэвэр, нийгмийн асуудлыг шийдэхээс гадна аялал жуулчлалыг дэмжих томоохон дэд бүтцийг бий болгож чадна.

- Улмаар дахин монголыг зорих жуулчид нэмэгдэж, хот хөдөөгийн амьдралын чанараас үүсэлтэй комплекс, хотжих, хөдөөгөөс дайжих үзэгдэлд тодорхой хувь нэмрээ оруулах боломжтой.

04 ТУРШИЛТЫНЗАГВАР

- Бидний хуурай (waterless toilet, compost toilet) 00 технологийн BIOLET Ver5 загвар АХБ (ADB venture)-ны нийгмийн инновацийн 7 хоногт (Social innovation week) түрүүлж байсан.

- Хүнсний хаягдал боловсруулагч загварыг 2 ресторан, 1 хүнсний үйлдвэр, 1 жуулчны бааз, 1 сургуульд тус тус хэрэгжүүлсэн.

- Ус цэвэршүүлэх системийг 1 авто зогсоол, 1 АОС хотхонд хэрэгжүүлсэн.

- Бүтэн цэвэрлэгээг 00 (FULLRELET) төсөл туршилтад явагдаж байна. Амжилттай болбол бохир усаа өөрийн усны хэрэглээнд дахин хэрэглэснээр усыг их хэмжээгээр хэмнэх болно.



ARTGER

FOOD | TRAVEL | CULTURE | PEOPLE

NEW VIDEOS EVERY WEEK!



Монголын хоолны соёлыг, түүнчлэн монгол ахуй, соёл, зан үйлээ хоолны нэвтрүүлгээр дамжуулан гадаад орчинд таниулан сурталчилж байгаа цорын ганц суваг бол "ArtGer". ArtGer нь үүсгэн байгуулагдсанаас хойш аль хэдийнээ монголын төдийгүй дэлхийн олон орны залуусын үзэх дуртай, дугаар бүрийг нь тэсэн ядан хүлээдэг сувгуудын нэг болсон бөгөөд 2017 онд үүсгэн байгуулагдсанаас хойш нийт 10 гаруй төслийн 220 дугаарыг гаргасан бөгөөд нийт 64 сая орчим хүн үзсэн байна.



Ингээд бид ArtGer сувгийг үүсгэн байгуулагч Р.ЖАВХЛАНТӨГСТЭЙ богино боловч маш сонирхолтой ярилцлагыг өрнүүлсэн юм.

Сайн байна уу. Юуны өмнө бидний урилгыг хүлээн авч, хол байгаа хэдийн ч цаг зав гарган ярилцлага өгөх болсонд баярласнаа илэрхийлж байна. Та өөрийгөө болон ArtGer сувгийнхаа талаар товч танилцуулахгүй юу.

Намайг Жавхлантөгс гэдэг, Дарханд төрж өссөн, сэтгүүлч мэргэжилтэн. Монголын хамгийн анхны хувийн телевиз болох RGB TV-д анхны ажлын гараагаа эхэлж байсан. Сүүлдээ фм, радио, видео студи, аудио студийг Улаанбаатар болон Дарханд ажиллуулж байсан. Тэгээд 2017 оноос албан ёсоор ArtGer сувгийг санаачилж, эхлүүлсэн. Багаасаа хоолонд их сонирхолтой, төрөл бүрийн хоол амсаж үзэх, судлах, мөн кино, видео хийх дуртай байсан.

ArtGer сувгийг үүсгэх санаа анх яаж төрсөн бэ?

Би өөрөө их хоолны хоббитой байсан болохоор Youtube дээрээс монгол хоолны контент байна уу гээд хайж үзсэн, тиймэрхүү контент аягүй бага, бараг гарч ирээгүй. Хэдэн жуулчдын л гар утсаараа бичсэн жижиг видеонууд л байсан. Тэгээд л яагаад монгол хоолны албан ёсны цуврал контентууд байж болохгүй гэж, бас мэргэжлийн түвшинд хийгээд тавих юм бол их нээлттэй, боломжтой юм байна гэж бодоод л эхэлсэн дээ.

Танай контентууд дан англи хэл дээр байдаг. Энэ нь анхнаасаа гадаад зах зээл рүү гарах зорилготой байсан гэж ойлгож болох уу?

Тиймээ. Анх бид монгол хэл дээр контент гаргавал гээд тооцоолж гаргасан, тэгэхэд маш бага тоо гарч байсан. Манай 3 сая гаруй хүний Youtube хэрэглэгчдийн тоо хэд байна, цаашдын төлөв ямар байх уу гэсэн тооцоолол хийхэд хангалттай байгаагүй. Тэгээд Youtube өөрөө дэлхийн хаанаас орж үзэж болдог суваг болохоор англи хэлээр контент гаргах нь илүү олон хүнд хүргэх боломжтой гэж харсан. Гэхдээ бидний 2-3 жилийн төлөвлөгөөнд монголчууд руугаа хандсан суваг үүсгэх ажил байгаа.



Танай контентууд монгол хоолыг зөвхөн чанасан мах, цагаан идээгээр төсөөлдөг хэвшмэл ойлголтоос салгаж, илүү баялаг өнцгөөс нь харуулж өгснөөрөө онцлог гэж санагддаг. Тиймдээ ч үзэгчдийн таашаалд хүрсэн байх.

Цаг үе өөрчлөгдөөд, цаг хугацаа өнгөрөх тусам аливаа уламжлалт соёл тодорхой хэмжээгээр хэлбэрээ өөрчлөөд, дараагийн шинэ үетэйгээ хөгжөөд явдаг нь байгалийн жам. Хоолны соёл ч мөн ялгаагүй. Бид монгол хоолоо зөвхөн махаар, цагаан идээгээр төсөөлөөд байж болох ч орчин үед энэ олон рестораныг ажилдуулж, олон

хүнийг хооллохын тулд бид энэ хоолнуудаа хөгжүүлэхээс өөр аргагүй болсон.

Тиймээс бид тэр талаас нь харуулах нь зүйтэй юм байна гэж бодсон. Мөн энэ нь зөвхөн монголын тухай асуудал биш гэж би харж байгаа. Бид монголоос эхэлсэн, монголын тухай үзүүлж байгаа нь үнэн. Гэвч энэ нь цаашаа олон жил үргэлжлэхийн тулд манай ArtGer-ийн сувгууд илүү даяарчлагдах болно. Хоол өөрөө маш том салбар учир цааш нарийн хөгжүүлэх боломж байна. Бусад орны хоолнуудыг өөрсдийн сувгуудаар үзүүлэх, монгол хоол өөр улс оронд яаж өөрчлөгдөж очсон эсвэл гаднын хоол монголд хэрхэн орж

ирсэн гэх мэт зүйл дээр ажиллах ёстой юм байна лээ. Яг энэ зарчмаар бид төлөвлөгөө гаргаад явж байгаа.

Танай сувгаар олон контентууд явдаг, тэдгээрийнхээ талаар ярихгүй юу. Яг ямар ямар контентууд хийгдэж байгаа вэ?

ArtGer Media Group гээд компани байгуулагдсан. Анхны үндсэн суваг болох ArtGer маань 4 жил болчихлоо. Шинээр 2-3 суваг нэмж хөгжүүлэх гэж байгаа. ArtGer үндсэн суваг маань хоолны контентоороо дагнаад явна. Анх бол дан ганц хоол бус соёл, аялал жуулчлал гэх мэт контентууд хийж байсан боловч үзэгчид маань хоолны контентоо үздэг, түүнийгээ л хүлээгээд байдаг байсан.

Тэгээд бид сувгаа ялгаж, задлах хэрэгтэй юм байна гэж бодсон. Тэгээд ArtGer Plus гэж цэвэр соёлын контентууд хийгдэх шинэ сувгийг эхлүүлэх гэж байгаа. Энэ зундаа багтаад эхэлнэ. Хажуугаар нь мөн Funkie Ger гээд суваг эхлүүлсэн, туршилтын журмаар явж байгаа. Энэ суваг маань илүү орчин үеийн залуучуудын амьдралын хэв маяг, тэдний сонирхлын тухай гарна, хөгжим, урлаг, хувцас загвар гэсэн категориудтай контент хийж туршиж байгаа.

Сүүлийн үед танай монгол хоолыг хээр талд, гадаа хийж байгааг харуулсан контент олны анхаарлыг татаж, ихээхэн яригдах болсон. Энэ санаа анх хаанаас төрсөн бэ?

Youtube үздэг хүмүүс сайн мэдэх байх. Энэ төрлийн контентууд дэлхий даяар 5-6 жилийн өмнөөс гараад эхэлчихсэн байсан. Улс бүр өөрсдийн онцлогоороо ийм төрлийн контентууд хийдэг байсан. Би тэгээд яг монголын онцлогийг харуулсан контент хийж болох юм байна гэж бодогдсон. Манай монголын соёл их баялаг.

Бид 4 улирал, гайхалтай байгаль, өвөрмөц дээл хувцас, малгай, хэт хутга гээд харуулж болох олон зүйл байдаг, тиймээс эдгээр дээр түшиглээд монголын хоолны контент хийх санаа төрсөн. Khan Kitchen-ийн тогооч нь манай төрсөн дүү байгаа юм. Мэргэжлийн тогооч хүн биш ч бас хоолны их сонирхолтой болохоор нь дүүдээ санал тавиад эхлүүлж байсан.

Тогоочийн хажууд байдаг нохой ямар учиртай вэ? Зураг авалт бүр онцлон харуулдаг шалтгаан нь юу вэ?

Банхар нохой бол цэвэр монгол нохой. Монголчууд эртнээс банхар нохойгоо тэжээж ирсэн байдаг. Мөн бид байгальтайгаа, ан амьтадтайгаа ойр байна гэсэн мессежээр харж болно.





ARTGER

FOOD / TRAVEL / CULTURE / PEOPLE
NEW VIDEOS EVERY WEEK

Та бүхний цаашдын төлөвлөгөө юу байна вэ?

Ажлуудаа 1, 3, 5 жилээр төлөвлөөд явж байна. Хамгийн ойрын төлөвлөгөө бол өмнө хэлснээр шинэ сувгуудаа ажилд оруулна. Нэвтрүүлгийнхээ шинэ улирлын дугааруудыг улам өргөжүүлж гаргахаар төлөвлөсөн. Гаднын байгууллагуудаас хамтран ажиллах саналууд ирсэн.

Тэр ажлуудаа явуулна. Мөн зөвхөн контент гэхгүй аялал жуулчлалын компаниа өргөжүүлэхээр төлөвлөгөө гаргаад ажиллаж байна. Түүний хажуугаар хүнсний бүтээгдэхүүн хөгжүүлэх ажил бас байгаа. Анхны бүтээгдэхүүнээр Mongolian barbecue sauce-г гаргахаар ажиллаж байна. Цаашлаад дан ганц монгол хоол гэхгүй азийн орнуудын хоолоор контент хийх санаа байгаа.

Гаднын байгууллагуудаас хамтран ажиллах санал ирж байгаа гэлээ. Яг ямар байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллахаар байгаа вэ?

"Food odds" гээд Японы хүнсний компаниас холбогдож, тэдний тогооч нартай хамтарсан контент хийсэн. Тэрний өмнө, Солонгосын KBS TV-тэй хамтарч Солонгос хоол Монголд ямар байна вэ гэсэн сэдвээр 4 дугаар нэвтрүүлэг хийсэн.

Мөн Youtube дээрх гаднын 1, 2-рт жагсдаг, 7, 8 сая дагагчтай томоохон сувгуудаас холбогдож, хил нээгдэхээр Монголд ирж, хамтарч нэвтрүүлэг хийх талаар санал тавьсан. ВВС-ээс бидэнтэй холбогдож, хамтарч ажиллах талаар яригдаж байгаа. Сүүлийн үед ӨМӨЗО-оос зөвхөн контент гэхгүй бизнесийн шугамаар хамтарч ажиллах талаар холбогдсон, судалгаа хийгээд явж байгаа.

Манай цахим товхимол нь гадаадын байгууллага, гаднын хөрөнгө оруулагчдад чиглэсэн, дийлэнх уншигчид нь гаднын хүмүүс байдаг учир тэдэнд монгол хоолны соёл, онцлог чанарын талаар өөрийн зүгээс санал бодлоо илэрхийлэхгүй юу.

Манай монголын соёл, зан заншил өөрөө их өвөрмөц. Одоо дэлхий хүн үүссэн анхны байдал руугаа очихыг улам л хүсээд байна гэж ойлгож байгаа. Улам минимал, улам байгаль дэлхийтэйгээ ойрхон байх амьдралын хэв маягийг илүүд үзэж байна. Гэтэл бид өөрсдөө ийм соёлтой шүү дээ.

Хээрийн хаана ч очсон гэрээ бариад, хоолоо хийгээд идчихдэг ард түмэн. Энэ соёлоо бид гадагшаага таниулж, сурталчлах хэрэгтэй байна, ийм боломж бас харагдаж байна. Гаднын хөрөнгө оруулагчидтай хамтраад маш бүтээлчээр хийх санаанууд харагдаж байгаа.

“Монгол орны ахуй соёл, уламжлалыг хоолоор дамжуулан олон орны үзэгчдэд хүргэж, Монгол Улсынхаа хөгжил, дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа Та бүхэнд талархаж буйгаа илэрхийлье. Та бүхний ажилд өндөр амжилт хүсье.



Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны албаны дарга

Б.ЦЭНД-АЮУШ

ARTGER
FOOD | TRAVEL | CULTURE | PEOPLE
NEW VIDEOS EVERY WEEK



f @ArtgerTV
y ARTGER



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



БИД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ХУУЛЬ ЁСНЫ ЭРХ АШГИЙГ ХАМГААЛНА.

БИД ТАНД ХЭРХЭН ТУСЛАХ ВЭ ?

“Хөрөнгө оруулагчаас гаргасан гомдлыг цахим хэлбэрээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих систем-SIRM”

SIRM систем нь Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг. SIRM системийг дэлхийн банк группийн олон улсын санхүүгийн корпорацын тусламжтайгаар боловсруулж, ашиглалтад оруулсан. Та ipc.gov.mn вэбсайтад хандан SIRM системтэй танилцарай.

Хөрөнгө оруулагч та SIRM системээр дамжуулан өргөдөл, гомдол гаргаснаар:

- Дэлхийн хаанаас ч, хэдийд ч гомдол гаргах боломжтой бөгөөд.
- Өөрийн гомдлыг ямар үе шатанд, хэрхэн шийдвэрлэгдэн явж буйг хянах.
- Төрийн байгууллагуудын олон талын оролцоотойгоор.
- Тогтоосон хугацаанд гомдлоо шийдвэрлүүлэх боломжтой болох юм.

Гомдол шийдвэрлэх
үйл явц




дэлгэрэнгүй


ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ



01
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ
Хөрөнгө оруулагч www.ipc.gov.mn
хаягт хандан гомдлоо гаргана.



02
АЖЛЫН АЛБА
Ажлын алба хүлээн авч,
ангилан, холбогдох
байгууллагуудруу илгээнэ.



03
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГУУД
Холбогдох төрийн байгууллагууд таны
гомдлыг судлан санал, дүгнэлт өгнө.
Санал, дүгнэлтүүд гомдол үүсгэгч
байгууллагад хүргэгдэнэ.



04
**ГОМДОЛ ҮҮСГЭГЧ
БАЙГУУЛЛАГА**
Ирсэн санал, дүгнэлтэд үндэслэн гомдлыг
шийдвэрлэж, системээр хариу өгнө



05
ЗӨВЛӨЛ
Гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд
Зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.



06
SIRM СИСТЕМ
SIRM систем танд и-мэйлээр
хариу өгөх болно.

SIRM систем нь төрийн байгууллага хоорондын албан тоот дамжуулах хугацаа алдагдлыг байхгүй болгож, Хөрөнгө оруулагчийн гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэнэ.

Улмаар Хөрөнгө оруулагчдад тулгарч буй асуудлуудын талаар нэгдсэн мэдээллийн сан бүрдэж, хууль эрх зүйн зохицуулалтыг

сайжруулах, бодлогын түвшинд өөрчлөлт хийх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах үндэс суурь тавигдах юм. SIRM системийг боловсруулж, ашиглалтад оруулахад үнэтэй хувь нэмэр оруулж, гүн тусалцаа үзүүлсэн Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацын хамт олонд талархал илэрхийлье.

SIRM СИСТЕМИЙН ГОМДЛЫНАНГИЛАЛ

SIRM систем нь Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хүнд суртал, хууль бус үйл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг. SIRM системийг дэлхийн банк группийн олон улсын санхүүгийн корпорацийн тусламжтайгаар боловсруулж, ашиглалтад оруулсан. Та ipc.gov.mn вэбсайтад хандан SIRM системтэй танилцарай.

БУЦААХ

1. Өмнө нь Зөвлөлөөр шийдвэрлэгдэж байсан;
2. Шүүх, хууль хяналтын байгууллагад уг асуудлаар хандсан;

ЗӨВЛӨЛИЙН ХУРЛААР ШИЙДВЭРЛЭХ:

1. Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар хураан авсан ба нөхөн төлбөр олгоогүй
2. Хөрөнгө оруулагчийн өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах, шилжүүлэх эрхийг хязгаарласан;
3. Хөрөнгө оруулагчдыг ялгаварлан гадуурхсан
4. Төрийн байгууллагын хууль бус үйл ажиллагаа.

ШИЛЖҮҮЛЭХ:

1. Хөрөнгө оруулагчийн гаргасан гомдол нь системийн дагуу шийдвэрлэх асуудалд үл хамаарах бол гомдлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагад нэн даруй шилжүүлнэ. Ингэхдээ хөрөнгө оруулагч системээр дамжуулан гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих, хариуг системээр авах боломжийг бүрдүүлнэ.

2019-2020 онуудад Зөвлөлд хандан нийт 11 гомдол ирсэн байна. Гомдлын төрөл, шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг дараах графикад үзүүлэв.

SIRM системд бүртгүүлэхэд зөвхөн и-мэйл хаяг шаардлагатай Хөрөнгө оруулалттай Холбоотой гомдлоо цахимаар илгээн шийдвэрлүүлээрэй www.ipc.gov.mn



INVEST IN MONGOLIA

-  Засгийн газрын 2-р байр, Нэгдсэн Үндэстний Гудамж, Улаанбаатар 15160
-  www.nda.gov.mn
-  [/investmongolgov](https://www.facebook.com/investmongolgov)
-  [/ndagovMN](https://twitter.com/ndagovMN)
-  info@nda.gov.mn
-  976-51-261589, 77778787

investmongolia.com



Empowering The Economic Development Of Mongolia